

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот
Төрийн ордон

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20,089,129.3 сая /хорин их наяд наян есөн тэрбум нэг зуун хорин есөн сая гурван зуун мянга/ төгрөгөөр баталсугай.

2.Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 21,372,400.2 сая /хорин нэгэн их наяд гурван зуун далан хоёр тэрбум дөрвөн зуун сая хоёр зуун мянга/ төгрөгөөр баталсугай.

ГАРЫН ҮСЭГ

“МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтад “Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтад Улсын Их Хурал “нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлах” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тус тус заасны дагуу “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тайлант онд улсын төсвийн нийт орлого ба тусламжийг 20,652.3 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 20,533.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 99.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан.

Төсвийн тогтворжуулалтын санд 478.6 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр ААНОАТ-ын орлогоос 144.4 тэрбум төгрөг, АМНАТ-ийн орлогоос 296.7 тэрбум төгрөг, бусад орлогоос 2.9 тэрбум төгрөг, нийт 443.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн.

Монгол Улсын 2024 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 20,089.1 тэрбум төгрөгт хүрч, 99.6 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөнөөс 84.6 тэрбум төгрөгөөр дутуу ч, өмнөх оны гүйцэтгэлээс 4,004.0 тэрбум төгрөгөөр буюу 24.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн нийт орлого ба тусламжийн дүн /тэрбум төгрөг/

| Үзүүлэлт | 2023 он | 2024 он | | | |
|---|-----------------|-----------------|-----------------|-------------|--------------|
| | Гүйц | Төлөв | Гүйц | Хувь | Зөрүү |
| Нийт орлого ба тусламжийн дүн | 17,177.3 | 20,652.3 | 20,533.0 | 99.4 | 119.2 |
| Тогтворжуулалтын сан | 675.9 | 478.6 | 443.9 | 92.8 | 34.7 |
| Ирээдүйн өв сан | 416.2 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Тэнцвэржүүлсэн орлого ба тусламж | 16,085.2 | 20,173.7 | 20,089.1 | 99.6 | 84.6 |
| Татварын орлого | 13,715.0 | 16,918.0 | 17,033.1 | 100.7 | 115.2 |
| Татварын бус орлого | 2,370.2 | 3,255.8 | 3,056.0 | 93.9 | 199.8 |

Монгол Улсын 2024 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 21,372.4 тэрбум төгрөг буюу 94.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Нийт зарлага ба цэвэр зээлийн 74.7 хувийг урсгал зардал, 23.8 хувийг хөрөнгийн зардал, 1.5 хувийг эргэн төлөгдөх цэвэр зээл эзэлж байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн /тэрбум төгрөг/

| Үзүүлэлт | 2023 он | 2024 он | | | |
|--|-----------------|-----------------|-----------------|--------------|----------------|
| | Гүйц | Төлөв | Гүйц | Хувь | Зөрүү |
| Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 16,079.8 | 22,677.8 | 21,372.4 | 94.2 | 1,305.4 |
| Урсгал зардал | 11,960.6 | 16,475.0 | 15,964.9 | 96.9 | 510.1 |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 3,614.5 | 8,057.8 | 7,781.5 | 96.6 | 276.2 |
| Хүү | 1,092.6 | 1,173.6 | 1,165.9 | 99.3 | 7.7 |
| Татаас ба урсгал шилжүүлэг | 7,253.5 | 7,243.7 | 7,017.5 | 96.9 | 226.2 |
| Хөрөнгийн зардал | 3,951.9 | 6,099.7 | 5,082.1 | 83.3 | 1,017.6 |
| Эргэж төлөгдөх цэвэр зээл | 167.3 | 103.1 | 325.4 | 315.5 | 222.2 |

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.1, 8.10.2 дахь заалтад тус тус заасны дагуу нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийлгэн улсын төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын хэмжээг баталгаажуулсан болно.

---o0o---